НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2023 оны 07 сарын 20 өдөр Дугаар 12 Улаанбаатар хот

НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ,
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
ГАЗАРТ

Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэлд:

"6.Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газраас дэвшүүлсэн "Цахим үндэстэн" болох зорилт, Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг хөгжлийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан цахим шилжилтийн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцын танилцуулгыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн танилцуулав.

Энэ асуудалтай холбогдуулан:

1.Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/912 дугаар захирамж болон Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан цахим шилжилтийн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг эрчимжүүлж, шуурхай зохион байгуулан ажиллахыг Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар /Б.Даваанням/-т;

2.Төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, худалдан авах ажиллагааг зарлахад шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /И.Баатархүү/, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулахыг Худалдан авах ажиллагааны газар /Г.Энхтайван/ нарт;

3.Нийслэлийн цахим шилжилтийн төсөл, арга хэмжээний хүрээнд үүсэн бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглээнд нэвтрүүлэх, иргэд олон нийтэд таниулан сурталчлах чиглэлд холбогдох арга хэмжээг авч, хамтран ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад;

4.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ суурилуулахтай холбоотой дэд бүтцийн хэвийн ажиллагааг хангаж, хэрэглээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг бүрэн хангахыг Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨТҮГ /С.Адъяасүрэн/, Нийслэлийн Замын цагдаагийн системийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар /Б.Даваанням/ нарт;

1110200151

5.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ /RFID TAG/-г суурилуулахтай холбоотой зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч ажиллах, иргэдийг энэ чиглэлийн мэдээллээр хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /И.Баатархүү/-т, холбогдох чиг үүргийн байгууллагуудын удирдлагуудад;

6.Дээрх үйл ажиллагаанд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэнд үүрэг болгов" гэжээ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ТТБ-2105